

Үндэсний статистикийн хорооны даргын  
2011 оны 9-р сарын 21-ний өдрийн  
01/133 тоот тушаалын II хавсралт

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

# **ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР НӨХӨХ ЗААВАР**

Улаанбаатар хот

2011 он

АГУУЛГА

НИЙТЛЭГ ЗҮЙЛ .....	3
НӨХӨХ ЗААВАР .....	4
I. НҮҮР, ХАЯГИЙН ХЭСЭГ .....	5
I (Б). ХАЯГИЙН ӨӨРЧЛӨЛТ .....	7
II. ТОВЧООЛСОН МЭДЭЭЛЭЛ .....	7
III (А). ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ҮНДСЭН БҮРТГЭЛ.....	8
III (Б). ӨРХИЙН ГИШҮҮДИЙН БҮРТГЭЛ .....	9
IV. ӨРХИЙН БҮРТГЭЛ.....	20
V. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТЭМДЭГЛЭЛ .....	27

## НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Засаг захиргааны анхан шатны нэгжээсээ эхлэн бүх шатанд хүн ам, өрхийн холбогдолтой тоо мэдээг үнэн зөв тодорхойлох, тооллого хоорондын хүн амын тоог хянах, тэдний нийгмийн үзүүлэлтээр мэдээллийн сан бүрдүүлэх эх үүсвэр бол хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр юм.

Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэрт тухайн өрхөд байгаа бүх хүний талаарх мэдээллийг бүртгэх бөгөөд түүнд үндэслэн тухайн оны сууринүж амын нас хүйсийн бүтэц, гэрлэлтийн байдал, суурьшил, шилжилт, ажил эрхлэлт, боловсрол, орон сууцны төрөл, дэд бүтцийн хангамж, өхцөл зэрэг өргөн мэдээллийг цуглуулж, засаг захиргааны үр нэгжээр боловсруулан гаргаж авдгаараа энэхүү дэвтэр чухал ач холбогдолтой. Уг дэвтэр нийгэм, эдийн засаг болонүж амын тооллого, түүвэр судалгааны анхан шатны нэгж, хамрах хүрээг тодорхойлох суурь мэдээлэл болно.

Энэхүү дэвтрийг хөтөлснөөр бүх шатны Засаг дарга нарт орон нутгийнхаа нийгэм, эдийн засгийн бодлогыг иж бүрнээр нь төлөвлөн боловсруулахад чухал шаардлагатай суурь мэдээллийг бий болгоно.

Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр нь өрхөд үлдэхгүй, бүртгэл хийж байгаа үндсэн нэгж болох баг, хорооны Засаг дарга нарт үлдэнэ. Хэрвээ өрх өөр аймаг, орон нутагт шилжих тохиолдолд хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээ шилжин ирсэн газартаа авч ирж бүртгүүлэх ёстой.

Өрх, хүн бүрийн мэдээллийн нууцыг “Хувь үний нууцын тухай” Монгол Улсын хуулийн (1995 оны) 5 дугааривийн 4 дэх хэсэгт “Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно”, “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт албан ёсны статистикийнүйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын ажилтан албан ёсоор мэдээлэх түвшинд хүрээгүй статистикийн мэдээлэл, судалгааны дүн, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нууцад хамаарах мэдээллийг нийтэд задруулахыг хориглоно” гэж заасны дагуу чандлан хадгална.

## НӨХӨХ ЗААВАР

Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр нь нүүр, хаягийн хэсэг, хаягийн өөрчлөлт, товчоолсон мэдээлэл, өрхийн гишүүдийн бүртгэл, өрхийн бүртгэл гэсэн бүтэцтэй. Дэвтрийг шинээр нээж бичихдээ **тосон бал, бэхээр** гаргацтай бичнэ. Харин тухайн өрхийн оршин сууж байгаа байршлыг дэлгэрэнгүйгээр тухайлбал, гудамж, хорооллын нэр, байшингийн болон хаалганы дугаар, утасны дугаар бичих хэсэгт **балын харандаа** ашиглана.

Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн асуулгыг нөхөхдөө дараах нийтлэг арга зүйг баримтална. Үүнд:

1. Дэвтрийн асуултыг дарааллаар нь асууж, хариултыг холбогдох кодын дагуу тэмдэглэнэ. Үүнд:

- i. Нүүр, хаягийн хэсэг
- ii. Хаягийн өөрчлөлт
- iii. Өрхийн гишүүдийн үндсэн мэдээлэл
- iv. Өрхийн бүртгэл
- v. Товчоолсон мэдээлэл

2. Хариултын кодыг өхөх болон дугуйлах байдлаар тэмдэглэх бөгөөд хариултын код нь тоогоор байвал өвхөн нэг хариултыг, үсгээр байвал нэгээс олон хариултыг тэмдэглэх боломжтой. Тухайлбал, асуултын хариулт нь өрхийн гишүүдийн бүртгэлийн хэсэгт ихэнх тохиолдолд нөхөх, харин өрхийн бүртгэлийн хэсэгт дугуйлж тэмдэглэхээр байгаа юм.

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН	СӨБ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТЫН БАЙДАЛ /2-39 НАС/	НИЙГМИЙН ХАЛАМЖИД ХАМРАГДСАН БАЙДАЛ
A8	A9	A10
3	1 1	a b c d e f g z

3. Асуултад олон хариулт өгөх тохиолдолд тохирох өвхөн нэг хариулт авна. Ингэхдээ өгсөн хариулт сайн ойлгогдохгүй бол лавлан асууж аль тохирох хариултыг эцэслэн авна.
4. Хариултын кодыг нөхөж байгаа тохиолдолд дөрвөлжин нүдэнд тоог нэг нэг оронгоор нь гаргацтай бичнэ. Дөрвөлжин нүдэнд бичигдэх тооны орон нь нүдний тооноос цөөн байвал өмнө нь “0” тавьж урагш нь гүйцээж бичсэн байх ёстой.
5. Өрхийн гишүүдийн бүртгэлийн A9, A12, A13-A16-р асуулт нь тодорхой нас зааж асуухыг сайтар анхаар.
6. Асуултад өгсөн хариултыг тэмдэглэхдээ тухайн хариултын холбогдох кодыг харгалзах нүдэнд нөхөх эсвэл дугуйлах бөгөөд хариултын кодыг зөв газарт тэмдэглэсэн эсэхээ хянах хэрэгтэй.

## I. НҮҮР, ХАЯГИЙН ХЭСЭГ

**Өрхийн бүртгэлийн дугаар /шинээр олгож буй/.** Өрхийн бүртгэлийн дугаарыг бүртгэл хийж буй анхан шатны нэгж олгоно. Өрхийн бүртгэлийн дугаарыг давхардуулан өгч болохгүй. Өрх 2 өрх болж салах, гэр бүлээ цуцлуулах, шинээр гэр бүл болж байгаа тохиолдолд өрхөд бүртгэлийн дугаарыг шинээр олгоно. Тухайн өрх хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээ нээлгэх үед дугаар авах ба энэ дугаар Монгол Улсын аль ч нутаг дэвсгэрт шилжин явсан, ирсэн тохиолдолд ч анхны авсан энэ дугаар өөрчлөгдөхгүй хэвээрээ байна. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр шинээр нээлгэсэн тохиолдолд өрхийн бүртгэлийн дугаар нь баг, хорооноос олгосон өрхийн дугаартай адил байна. Хэрвээ өрх өөр газраас шилжиж ирсэн тохиолдолд өрхийн бүртгэлийн дугаар нь өөрчлөгдөхгүй хэвээрээ байх ба өрх ирсэн газартаа бүртгүүлж хаягийн өөрчлөлтийн хэсэгт баг, хорооноос олгосон өрхийн дугаарыг шинээр авах бөгөөд энэ нь ялгах кодоор ялгагдах болно.

Өрхийн бүртгэлийн дугаарын эхний “1-6” орон нь аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны код байна. Кодыг нөхөхдөө мөрдөгдөж буй “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”-ыг ашиглана.

Өрхийн дугаарын оронгийн тоо:

- 1-2 Аймаг, нийслэлийн код /A1/
- 3-4 Сум, дүүргийн код /A2/
- 5-6 Баг, хорооны код /A3/
- 7-10 Өрхийн бүртгэл хийгдсэн дугаар бөгөөд баг, хороо бүр өрхийг 0001-ээс эхэлж бүртгэнэ. /A5/
- 11 Бүртгэл хийсэн оны сүүлийн оронг тавина. Жишээ нь 2012 онд бүртгэл явагдаж байгаа бол 11-р орон “2” болно.
- 12 Бүртгэлийн ялгах кодыг дараах байдлаар нөхнө.

- Ялгах код нь:
- 1- Үндсэн өрх
  - 2- Өрхийн дугаар шинээр авч буй өрх
  - 3- Шилжиж ирсэн өрх

**Үндсэн өрхөд** тухайн орон нутагт 6, түүнээс дээш сарын хугацаагаар байнга оршин сууж байгаа өрхийг ойлгоно.

**Өрхийн дугаар шинээр авч буй өрхөд** урьд өмнө нь өрх үүсгэн амьдарч байгаагүй, анх удаа өрх тусгаарлаж байгаа, өрхийн тэргүүлэгч нас барсан, гэр бүлээ цуцлуулаад шинээр өрх үүсгэж байгаа өрхийг хамруулна.

**Шилжиж ирсэн өрхөд** бусад аймаг, орон нутгаас тухайн орон нутагт шилжиж ирсэн өрхийг оруулна.

Жишээлбэл, 2011 онд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1-р багийн эхний өрхийг үндсэн өрх гэж үзвэл дараах байдлаар нөхнө.

**ӨРХИЙН ДУГААР:** шинээр олгож буй

6	5	0	1	5	1	0	0	0	1	1	1
A1		A2		A3		A5			Ялгах код		

**Цээж зураг.** Өрхийн тэргүүлэгчийн цээж зургийг наана.

**Өрхийн тэргүүлэгч:** Өрхийн тэргүүлэгч нь тодорхойгүй нөхцөлд ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгчээр сонгохыг өрхийн гишүүдийн сайн дурын үндсэн дээр шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгч ид 16-аас дээш настай, ажил хөдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүнийг тодорхойлж болно. Тэгэхдээ өрхийн 16 нас хүрсэн гишүүдийн саналыг харгалзах хэрэгтэй.

**Өрхийн тэргүүлэгчийн:**

**Ургийн овог.** Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 7-д заасны дагуу “Ургийн овог овог дээдсээс гаралтай эцгийн талын холбоо бүхий бүлэг хүмүүсийн дунд үе уламжлан хэрэглэгддэг нэрийг хэлнэ” гэсэн заалтыг үндэслэн ургийн овгийг асууж, товчлохгүйгээр бичнэ. Мөн иргэний үнэмлэхээс харж баталгаажуулна.

**Эцгийн /эхийн/ нэр.** Гэр бүлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 -т “Хүүхэд эцгийн нэрийг авна”, мөн зүйлийн 4-т “Гэрлэлтээ бүртгүүлээгүй эхээс төрсөн, эсвэл хүүхдийн эцгийг тогтоосон эрхийг байгууллагын шийдвэргүй бол хүүхэд эхийн нэрийг авна” гэсэн заалтуудыг үндэслэн эцэг/эхийн нэрийг товчлохгүйгээр бичнэ.

**Өөрийн нэр.** Тухайн хүний нэрийг товчлохгүйгээр бичнэ. Хэрэв тухайн хүн хоёр нэртэй байвал албан ёсны буюу иргэний бичиг баримт дээр бичигдсэн нэрийг нь бичнэ. Эцгийн/эхийн нэрийн төгсгөлд “ийн”, “ын” дагавар залгахгүй.

**Холбоо барих утасны дугаар.** Өрхийн суурин эсвэл өрхийн тэргүүлэгчийн үүрэн утасны дугаарыг бичнэ.

**ХАӨБ-ийн 2006-2010 онд олгосон дэвтрийн дугаар:** Өмнө хөтөлж байсан буюу 2006-2010 оны хооронд нээж хөтөлсөн дэвтрийн “**Өрхийн дугаар**”-ыг нөхнө.

**A1-A4. Аймаг, нийслэл, сум, үүрэг, баг, хороо, тосгоны нэр, дугаар:** Аймаг, нийслэл, сум, үүрэг, баг, хорооны албан ёсны нэрийг товчлохгүйгээр гаргацтай бичиж, кодыг харгалзах үндэнд бичнэ. Кодыг нөхөхдөө мөрдөгдөж буй “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”-ыг ашиглана.

**A5. Баг, хорооноос олгосон өрхийн дугаар.** Өрхийн дугаарыг олгохдоо баг, хороо үр 00 01-ээс эхлүүлэн нэгдсэн дугаар олгоно. Өрхийн дугаарыг харгалзах нүдэнд гаргацтай бичнэ. Энэ дугаар нь өрхийн дугаарын “**A5**” дугаартай ижил байна.

**A6. Байршлын код.** Өрхийг оршин суугаа байршлаар нь нийслэл, аймгийн төв, тосгон, сумын төв, хөдөө гэж ангилан тохирох кодыг нөхнө.

## I (Б). ХАЯГИЙН ӨӨРЧЛӨЛТ

**Гудамжны нэр.** Өрхийн сууж байгаа өвөлжөө, гудамж, хорооллын албан ёсны нэрийг товчлолгоор бичнэ. Жишээ нь “Чингисийн өргөн чөлөө”, “Тээвэрчдийн гудамж”, “Нарлаг хороолол” гэх мэтчилэн бичнэ.

**Байшин/байр, хашаа, хаалганы дугаар.** Өрхийн оршин сууж буй байшин/байр, хашаа, хаалганы дугаарыг орон, оронгоор нь салгаж гаргацтай нөхөж бичнэ. Хөдөөгийн өрхийн хувьд амьдарч байгаа газар, уул, ус, өвөлжөөний нэрийг бичнэ.

Орон сууцны хороолол:

Гэр хороолол:

Хөдөө:

<i>Гудамжны нэр: Ажилчны гудамж</i>	<i>Гудамжны нэр: Хангайн 5</i>	<i>Гудамжны нэр: Мухарт</i>
<i>Байшингийн дугаар: 15</i>	<i>Байшингийн дугаар:</i>	<i>Байшингийн дугаар:</i>
<i>Хашаа/ хаалганы дугаар: 5-16</i>	<i>Хашаа/ хаалганы дугаар: 7-9</i>	<i>Хашаа/ хаалганы дугаар: Болдын өвөлжөө</i>

**Холбоо барих утасны дугаар.** Тухайн өрхийн суурин болон өрхийн тэргүүлэгч, эсвэл насанд хүрсэн өрхийн аль нэг гишүүний үүрэн утасны дугаарыг бичнэ.

**Гудамжны нэр, байшин/ байр, хашаа, хаалганы дугаар, болон холбоо барих утасны дугаарыг зөвхөн балын харандаагаар нөхнө.**

**Өөрчлөлт орсон эсэх.** Энэ хэсгийг шилжих өдөлгөөнд орсон эсэхийг үл хамааран он бүрт хөтлөх бөгөөд тухайн өрх өөр газарт өрхөөрөө шилжин ирж, явж байгаа бол “Тийм” гээд хаягийн хэсгийг нөхсөнтэй адил зарчмаар нөхнө.

## II. ТОВЧООЛСОН МЭДЭЭЛЭЛ

**D1. Ам бүлийн тоо (оны эхэнд)** өмнөх оны эцэст бүртгэгдсэн өрхийн гишүүдийн тоотой тэнцүү байна.

**D2. Төрсөн.** Бүртгэл явагдаж буй онд төрсөн хүүхдийн тоог бичнэ.

**D3. Нас барсан.** Бүртгэл явагдаж буй онд нас барсан хүний тоог бичнэ.

**D4-D9.** Бүртгэл явагдаж байх үед өрхөд гарсан хөдөлгөөнийг бичнэ. Өөрөөр хэлбэл, тухайн өрхөд 6, түүнээс дээш сарын хугацаагаар шилжиж ирсэн, явсан хүнийг харуулах бөгөөд дотоод болон гадаад гэж ангилан, харгалзах нүдэнд нөхнө. Дотоод шилжих өдөлгөөнд сум, дүүрэг, баг, хороо, аймаг, нийслэл хоорондын, гадаад шилжих өдөлгөөнд олон улс хоорондын шилжих өдөлгөөнийг хамруулна.

**D10.** Өрхийн гишүүдийн бүртгэлд бичигдсэн хүний нийт тоо буюу өрхийн маягтын А1- асуултын хүний тоотой тэнцүү байна. Өөрөөр хэлбэл оны эхэнд байсан гишүүдийн тоон дээр төрсөн, шилжин ирсэнийг нэмээд, нас барсан, шилжин явсныг хасаж, оны эцэст байгаа хүний тоог гаргана.

**D11-D16.** Өрхийн гишүүдийг насны бүлгээр нь ангилан бичнэ.

**D17-D20.** Өрхийн гишүүдийн мэдээллийг нэгтгэж тавина.

**“Товчоолсон мэдээлэл”үсмэгтийн доор бичигдсэн балансын шалгалтыг заавал хийнэ.**

### **III (А). ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ҮНДСЭН БҮРТГЭЛ**

Энэ хэсгийнүзүүлэлтүүд нь нэг л удаа бүртгэгдэх бөгөөд цаашид дахин бүртгэх шаардлагагүй. Өрхийн гишүүдийн үндсэн бүртгэлийг хийхдээ тухайн өрхийн тэргүүлэгчийн ургийн овог, эцэг/ эхийн нэр, нэрийг эхлээд, дараа нь өрхийн бусад гишүүдийг дараалуулан бичиж, холбогдох үзүүлэлтүүдийг нөхнө. Ингэхдээ “өрхийн тэргүүлэгчийн хамаарал” гэсэн кодын дарааллыг ашиглана.

**Өрх.** Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэгүлэг хүмүүсийг оруулна. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй ч байж болно. Өрх нь **гэр бүл** гэдэг ойлголтоос ялгаатай. Нэгэрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно. Эсвэл өрхийн гишүүдээс асуух асуултын хариултыг кодын хамт дэвтрийн эхнийүүрэнд оруулсан бөгөөд хариулагчийн өгсөн хариултыг зөв тодорхойлж зохих кодыг харгалзах нүдэнд бичнэ. Нэг орон сууц, байранд хамт амьдарч байгаа боловч ураг төрлийн болон гэр бүлийн холбоогүй хүмүүсийг дараах тохиолдолд өрх гэж үзэхгүй бөгөөд дэвтэр нээхгүй. Үүнд:

- а. Оюутан, сурагчдын дотуур байр болон ажиллагчдын нийтийн байр, цэргийн хүрээ, эмнэлэг, сувилал, асрамжийн газарт нэг өрөө тасалгаанд хамт амьдарч байгаа ураг төрлийн болон гэр бүлийн холбоогүй хүмүүс;
- б. Барилгын дээвэр, хонгил, орц, дулааны шугамүлжээний суваг, ой мод, уул, хад зэрэгт байрлаж байгаа гэр бүлийн болон ураг төрлийн холбоогүй хүмүүс;
- в. Айлын сууц буюу сууцны нэг хэсгийг өлслөн сууж байгаа ураг төрлийн болон гэр бүлийн холбоогүй хүмүүс;

**A1. Ургийн овог.** Өрхийн тэргүүлэгчийн иргэний үнэмлэх дээр байгаа ургийн овгийг жишээлбэл, “Боржигон” гэх мэтээр товчлолгүй гаргацтай бичнэ.

**A2. Эцэг/ эхийн нэр, өөрийн нэр.** Тухайн үний эцгийн/эхийн болон өөрийнх нь нэрийг товчлохгүйгээр бүрэн гүйцэд бичнэ. Хэрэв хоёр нэртэй байвал албан ёсны буюу иргэний бичиг баримт дээр бичигдсэн нэрийг нь бичнэ.

**A3. Өрхийн тэргүүлэгчийн хамаарал.** Тухайн гишүүн өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болохыг асууж, харгалзах кодын дагуу нөхнө. Хэрвээ бүртгэл хийлгэж байгаа үн нь өрхийн тэргүүн биш бол энэ асуултын хариултыг авахдаа болгоомжтой хандаж, тухайн үнээс өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болохыг нь асууж байгаа болохоос биш тухайн үнтэй ямар хамааралтайг нь асуугаагүй гэдгийг сайтар хэлэх хэрэгтэй.

**Эхнэр/ нөхөр.** Гэрлэсэн буюу хамтран амьдарч буй харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг,

**Хүү/ охин.** Төрсөн болон өргөмөл, дагавар хүү, охиныг,

*Эцэг/ эх.* Төрсөн болон хойт эцэг, эхийг,

*Ах/ эгч/ дүү.* Төрсөн болон хойт эцэг, эхийн хүүхэд, өргөмөл ах, эгч, дүүг,

*Хадам эцэг/ эх.* Өрхийн тэргүүлэгчийн эхнэр/ нөхрийн төрсөн, өргөж авсан болон хойд эцэг эхийг,

*Хүргэн/ бэр.* Төрсөн болон өргөмөл, дагавар хүү/ охины нөхөр/ эхнэрийг,

*Өвөг эцэг/ эмэг эх.* Өрхийн тэргүүлэгчийн эмээ, өвөөг,

*Ач/ зээ.* Төрсөн болон өргөмөл, дагавар хүү, охины хүүхдийг,

*Бусад өрөл төрөгсөд.* Өрхийн тэргүүлэгчийн өөрийн авга, нагац хамаатнууд болон эхнэр/ нөхрийн авга, нагац хамаатнууд, тэдгээрийн эхнэр/ нөхөр, хүүхэд, ах, эгч, дүү, эмээ, өвөөг тус тус хамааруулна.

*Хамааралгүй.* Өрхийн тэргүүлэгчтэй ураг төрлийн болон гэр бүлийн ямар нэг хамааралгүй, тусдаа өрх үүсгээгүй хүмүүсийг хамааруулна.

**Төрсөн огноо:** Тухайн хүний төрсөн огноог харгалзах нүдэнд нөхнө. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, бусад баримт бичигтэй өрүүлэхгүй байхыг хариулагчид сануулах хэрэгтэй ба иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичигтэй тулгаж үзнэ.

**А4. Хүйс.** Хүний нэр, гадаад төрх, зүс царай, хувцсаар хүний хүйсийг шууд тодорхойлж болохгүй, заавал асууж нөхнө.

**А5. Ясүндэс.** Асуултыг асууж, хариултыг тохирох кодын дагуу Хүүхдийн яс үндсийг эцэг, эх нь тодорхойлно. Хэрэв эцэг, эх нь тодорхойлж чадахгүй тохиолдолд хүүхдийн яс үндсийг эхийнхтэй ижил нөхнө.

**А6. Регистрийн дугаар, иргэний үнэмлэх/ төрсний гэрчилгээний дугаар.** Иргэний бичиг баримт дээр дэслэн 16, түүнээс дээш насны хүний хувьд регистрийн дугаарыг иргэний үнэмлэхний дугаарын хамт, түүнээс доош насны хүүхдүүдийн хувьд регистрийн дугаарыг төрсний гэрчилгээний дугаарын хамт бичнэ. Баганын эхний мөрөнд регистрийн дугаарыг, доод мөрөнд иргэний үнэмлэх/ төрсний гэрчилгээний дугаарыг тавина. Хэрэв иргэний үнэмлэхээ шинээр дахин авсан бол хуучин дугаарыг цэвэрхэн дарж, шинэ дугаарыг бичнэ.

### III (Б). ӨРХИЙН ГИШҮҮДИЙН БҮРТГЭЛ

**А7. Суурьшил.** Бүртгэл хийж байх хугацаанд тухайн иргэн оршин сууж байгаа засаг захиргааны нэгжид 6 сар, түүнээс дээш, доош хугацаагаар амьдарч байгаа эсэхийг харгалзан суурьшлын байдлыг тодорхойлно.

*Байнгын оршин суугч:* Байнгын оршин суугчид дараах хүнийг хамруулна. Үүнд:

- a. Бүртгэл явагдаж байх үед тухайн засаг захиргааны нэгжид 6 сар, түүнээс дээш буюу 183 хоног, түүнээс дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн.
- b. Бүртгэл явагдаж байх үед тухайн засаг захиргааны нэгжид 6 сараас доош буюу 183 хоногоос доош хугацаагаар амьдарч байгаа ч цаашид 6 сараас дээш хугацаагаар оршин суух хүн;

с. Өмнөх хүн ам, өрхийн бүртгэлд байнга суугаагаар бүртгэгдсэн боловч бүртгэлийн үед өрхдөө байхгүй дараах хүнийг байнга оршин суугчаар бүртгэнэ. Үүнд:

- Ээлжийн амралттай хүн;
- Харуул, манаа, жижүүрийн ажилтай хүн;
- Албан ажлаа олон хоногдөр элжлүүлэн гүйцэтгэдэг (төмөр замчид, агаарын болон авто тээврийн ажиллагчид, геологичид гэх мэт) хүн;
- Амралт сувилал, аялал жуучлалаар явсан гэртээ эргэж ирэх хүн;
- 24 цагийн ажиллагаатай ясли, цэцэрлэгт хамрагдсан хүүхэд;
- Албан томилолтоор гадаадад хурал өгөн, сургалтад хамрагдсан хүн;
- Замд буюу хээр яваа (түлээ түүх, мал хариулах, алдсан малаа хайж яваа, ан гөрөө хийж яваа гэх мэт) хүн;

*Тухайн онд төрсөн:* Тухайн онд төрсөн хүүхдийг,

*Цэргээс ирсэн:* Тухайн онд хугацаат цэргийн албанаас халагдаж ирсэн иргэнийг,  
*Сургууль төгсөж ирсэн:* Дотоодын аль нэг шатны сургуулийг төгсөж ирсэн хүнийг,

*Гадаадаас ирсэн:* Аль нэг улсад суралцах, ажиллах гэх мэт шалтгаанаар 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаад ирсэн хүнийг,

*Нас барсан:* Тухайн онд нас барсан хүнийг,

*Цэрэгт явсан:* Тухайн онд цэргийн албанд явсан хүнийг,

*Сургуульд явсан:* Дотоодын аль нэг шатны сургуульд суралцахаар явсан хүнийг,

*Гадаад явсан:* Аль нэг улсад суралцах, ажиллах гэх мэт шалтгаанаар 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суухаар явсан хүнийг,

*Бусад шалтгаанаар ирсэн, явсан:* Дээрхээс бусад шалтгаанаар ирсэн, явсан иргэдийг тус тус хамааруулна.

Жишээ нь: Хорих ангид ял эдлээд ирсэн гэх мэт...

**А8. Боловсролын түвшин.** Энэ асуултыг 6, түүнээс дээш настай бүх хүнээс асууна. Энэ асуултаар хариулагчийн боловсролтой эсэх, боловсролтой бол эзэмшсэн боловсролын дээд үвшинг асууж байгаа бөгөөд эхлээд “Та ямар нэг шатны боловсролтой юу?” гэж асуугаад тийм гэж хариулсан тохиолдолд эзэмшсэн боловсролын дээд түвшинг тодруулан асууж тохирох кодыг нөхнө.

Боловсролын дээд үвшин гэдэгт тухайн үжий эзэмшсэн боловсролын хамгийн дээд үвшинг ойлгоно. Жишээлбэл, иргэн Цэрэндулам Санхүү, эдийн засгийн техникумд (хуучин нэрээр) суралцаж, тусгай мэргэжлийн дунд боловсролтой, нягтлан бодогчийн мэргэжил эзэмшсэн боловч дараа нь дээд сургуулийг ямар нэг мэргэжлээр эрсдэд, магистрын зэрэг хамгаалсан бол Цэрэндуламын боловсролыг магистр буюу “8” гэсэн кодоор нөхнө.

*Боловсролгүй:* Ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангид одоо сурч байгаа үүхэд эсвэл 1 -5-р ангид сурч байгаад орхигчийг боловсрол эзэмшээгүй гэж үзнэ.

Бүрэн дунд хүртэлх боловсролын түвшинг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

Боловсролын түвшин  Он	Боловсролгүй	Бага	Суурь (Бүрэн бус дунд)	Бүрэн дунд
1975 хүртэлх онуудад	4-р ангийг төгсөөгүй.	4-р анги төгссөн.	7-р анги төгссөн.	10-р анги төгссөн.
1975-1996 онуудад	3-р ангийг төгсөөгүй.	3-р анги төгссөн.	8-р анги төгссөн.	10-р анги төгссөн.
1997-2004 онуудад	4-р ангийг төгсөөгүй.	4-р анги төгссөн.	8-р анги төгссөн.	10-р анги төгссөн.
2005 онд	5-р ангийг төгсөөгүй.	5-р анги төгссөн.	9-р анги төгссөн.	10-р анги төгссөн.
2006 бүнээг хойши онуудад	5-р ангийг төгсөөгүй.	5-р анги төгссөн.	9-р анги төгссөн.	11-р анги төгссөн.

Боловсролын аль нэг үвшинд өдөр, орой, эчнээгээр өгссөн болон албан бус боловсролын дийцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүмүүсийг хамруулна.

*Техникийн болон мэргэжлийн боловсрол:* Техник болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага (хуучнаар мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв-МСҮТ, техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж ойлгоно.

*Тусгай мэргэжлийн дунд боловсрол:* Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль өгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

*Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор бүнээс дээш/:* Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийн өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом бүнээг адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмүүлэх дипломын сургалт 9 0 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахин өдөрмөчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг **дипломын дээд боловсролтой** гэж үзнэ.

**А9. СӨБ, сургуульд хамрагдалтын байдал /2-39 нас/.** Энэ асуултыг 2-39 насны хүнээс асууж, хариултыг өхнө. Ерөнхий боловсролын сургууль /ЕБС/, техникийн болон мэргэжил боловсролын сургалтын байгууллага /ТМБСБ/ буюу хуучнаар мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв /МСҮТ/, их дээд сургуульд сурч байгаа хүмүүсийг **дотоодод, гадаадад** гэж салгаж холбогдох кодоор нөхнө. Харин

ямар нэг шатны боловсрол олгодоггүй албан бус боловсролын сургалтад хамрагдагчдыг сургуульд суралцагч гэж үзэхгүй.

Албан бус боловсролын сургалт гэж сургуулиас гадуурх зохион байгуулалттай сургалтын үйл ажиллагааг ойлгох бөгөөд төрөл бүрийн мэргэжил олгох /жолооны, гадаад хэлний, тогоочийн, компьютерийн зэрэг/ эсвэл амьдрах ухаанд сургах /ногоо тарих, алт, мөнгөний дархан зэрэг/ сургалтыг хамруулна. Алсын зайн сургалт нь албан бус боловсролын сургалтад хамаарна.

*Ерөнхий боловсролын сургууль /ЕБС/.* Ерөнхий боловсролын сургуулийн аль нэг ангид сурч байгаа хүүхдийг,

*Техник болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага /ТМБСБ/.* Техник болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын (хуучнаар мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв) аль нэг ангид сурч байгаа хүүхдийг,

*Их, дээд сургууль.* Улсын болон хувийн их, дээд сургууль, коллежид суралцагчыг,

*Сургуулийн өмнөх боловсрол /СӨБ/.* Цэцэрлэгт явж буй 2-6 үртэлх насны хүүхдийг тус тус хамруулна.

*Сургууль завсардсан.* Ерөнхий боловсролын сургуулийн аль нэг ангид сурч байгаад дахин суралцаагүй, сургуулиа орхисон хүүхдийг сургууль завсардсан гэж үзнэ.

*Гэртээ.* Ясли/цэцэрлэг, сургуульд огт явж байгаагүй хүмүүсийн хамруулна.

**А10. Нийгмийн халамжид хамрагдсан байдал:** Тухайн иргэнээс нийгмийн халамж болон хүний хөгжил сангаас олгож буй хувь, хишигт хамрагдсан байдлыг асуун холбогдох кодыг нөхөн бичнэ. Энэ асуулт нь олон хариулттай байж болно.

Нийгмийн халамжийн шинэчилсэн хуулийн дагуу дараах төрлүүдийг оруулав. Үүнд:

#### **Нийгмийн халамжийн тэтгэвэр**

- Ахмад настны халамжийн тэтгэвэр /17.1.1 заалт/;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр /17.1.2/;
- Дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх /50 насанд хүрсэн эцэг/-ийн халамжийн тэтгэвэр /17.1.3/;
- Тэжээгч нь нас барсан ~~төрийн~~ 18 хүртэлх насны хүүхдийн халамжийн тэтгэвэр /17.1.4/;

#### **Нийгмийн халамжийн өхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ**

- Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж /19.1.2 заалт/;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох тэтгэмж /19.1.3/;
- Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж /19.1.5/;

- Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон жүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие мах бодийн хохирол эзж хамгаалалт шаардлагатай болсон үүхдийг гэр бүл дээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж /19.1.6/;
- Ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж /19.1.7/;
- “Эхийн алдар” нэгдүгээр, эсхүл хоёрдугаар зэргийн одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламж /19.1.8/;
- Эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам олгох тэтгэмж /19.1.9/

#### **Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай, иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламж**

- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж /25.1.1 заалт/;
- Орон сууцны хөлсний болон түлшний үнийн хөнгөлөлт /25.1.2/;
- Халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт /25.1.3/;
- Протез, ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслэлийн хангамж /25.1.4/;
- Сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт /25.1.5/;
- Эх орны рашаан сувиллын зардлын хөнгөлөлт /25.1.6/;

#### **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ**

Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор зөвлөлгөө өгөх, сургалт зохион байгуулах /26.1.1/;

- Зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах /26.1.2/;
- Сэргээн засах үйлчилгээнд хамруулах /26.1.3/;
- Түр байрлуулан асрамжлах /26.1.4/;
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах /26.1.5/;

#### **Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ**

- Ахмад настны асрамжийн /28.1.1/;
- Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн /28.1.2/;
- Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн асрамжийн /28.1.3/;
- Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн /28.1.4/;

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай шинэчилсэн хуулийн дагуу “**ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлтөд**” дараах тусламж, хөнгөлөлт орно.

- Хөл, гар, цүд (үнэт металлаар хийхээс бусад) -ний протез, сонсох,

харах эрхтний ортопедийн хэрэгсэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутам нэг удаа нөхөн олгох (хуулийн 5.1.1 заалт);

- Ахмадын зориулалттай амралт, сувилалын газарт амрах эрхийн бичгийг хөнгөлөлттэй үнээр олгох (5.1.2);
- Тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд болон хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох (5.1.3);
- Хүндэт донор ахмад настан болон эмчилгээ, сувилгаа зайлшг шаардлагатай ахмад настан эмнэлгийн байгууллагуудад тээвэр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох (5.1.4);
- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, ганц бие ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний тусламж олгох (5.1.5);
- Нийслэл, аймгийн өвийн нийтийн тээврийн хэрэгсэл (таксинаас бусад)-ээр орон нутгийн харьяалал харгалзах үнэ төлбөргүй зорчих (5.1.6);
- Худалдаа, тээвэр, холбоо, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний газар тэргүүн ээлжинд үйлчлэх (5.1.7);
- Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох (5.1.8);
- Ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөр/-т сар бүр мөнгөн тусламж үзүүлэх (5.1.9);
- Монгол Улсын төрийн соёрхолт, түүнчлэн Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад үтгэлтэнд жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлэх (5.1.10);
- Монгол Улсын болон орд, хөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, төрийн соёрхолт, ахмад дайчин, Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад үтгэлтэнд энэ хуулийн 5.1.8 -д зааснаас гадна дор дурдсан хөнгөлөлтийг үзүүлнэ (5.1.11):
  - а. нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардлыг жилд нэг удаа олгох (5.1.11);
  - б. дотоодын рашаан сувилалд ирэх, буцах замын зардал, эрхийн бичгийн үнийг жилд нэг удаа нөхөн олгох (5.1.11);
  - в. орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц,

гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох (5.1.11);

**Хүнийг хөгжил сангийн хишиг, хувьд** тус сангийн хуулийн дагуу хүн ам, ерхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэн бүрт олгож буй хишиг, хувийг ойлгоно.

**А11. Хөгжлийн бэрхшээлтэй эсэх .** Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг нь сайтар лавлан асууж кодыг харгалзах нүдэнд бичнэ.

Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэх согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэнэ. Мөн энд хөдөлмөр магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй болох нь тогтоогдсон хүнийг хамруулна.

Хөгжлийн бэрхшээлийн төрөлд хөгжлийн бэрхшээлийн үүсэл, гарлыг хамааруулна.

*Төрөлхийн.* Хөгжлийн бэрхшээлийн төрөлд удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэх согог той болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг ойлгоно.

*Олдмол.* Хөгжлийн бэрхшээлийн төрөлд ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалахэвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэх согог той болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг ойлгоно.

Хөгжлийн бэрхшээлийн илэрсэн хэлбэрийг дараах байдлаар ойлгоно.

*Харааны.* Харааны эрхтний гэмтэл, согог, өвч ин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан,

*Ярианы.* Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан,

*Сонсголын.* Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан,

*Хөдөлгөөний.* Биеийнхээ тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан,

*Сэтгэцийн.* Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илэрхийлэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн . Гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцооны дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх ажиллагаа нь хязгаарлагдсан оюун ухааны бэрхшээлийг сэтгэцийн эмгэгт ойлгоно.

*Бусад.* Хөгжлийн бэрхшээлийн дээр дурьдсан хэлбэрээс бусад хэлбэрийг үүнд хамааруулна. Тухайлбал, дотор эрхтний өвчин эмгэг болон хоёр ба түүнээс дээш хөгжлийн бэрхшээл нэг хүнд хамт илэрч байвал бусдад хамааруулна.

**А12. Гэрлэлтийн байдал.** Энэ асуултыг бүртгэл хийх үеийн байдлаар, 16, түүнээс дээш насны хүн бүрээс асууна. Гэр бүлийн тухай хууль болон уламжлалт ёсны дагуу тухайн үжий гэрлэлтийн байдлыг дараах өрлүүдээр тодорхойлно. Үүнд:

*Огт гэрлээгүй.* Арван тав, түүнээс дээш насны, огт гэрлэж байгаагүй хүнийг,

*Батлуулсан.* Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүнийг,

*Батлуулаагүй.* Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүнийг тус тус хамуулна. Хэрвээ 18 нас хүрээгүй боловч гэр бүлтэй болсон байвал тэдгээрийг “батлуулаагүй гэр бүлтэй” гэж үзнэ.

*Тусгаарласан.* Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа хүмүүсийг хамруулна. Гэхдээ албан ажлын улмаас 2 тусдаа амьдарч байгаа хүмүүсийг тусгаарласан гэж үзэхгүй.

*Цуцалсан.* Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойшхи хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй хүнийг,

*Бэлбэсэн.* Эхнэр/ нөхрийн аль нэг нь нас барснаас хойш хичнээн хугацаа өнгөрснийг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй хүнийг тус тус хамруулна.

Гэрлэлтийн байдлыг өмнөхөө бүртгэл хийх үеийн байдлаар тодорхойлж нөхөхийг анхаарах хэрэгтэй. Жишээлбэл, иргэн Бат Цэцэгтэй батлуулсан гэр бүлтэй байж байгаад гэрлэлтээ цуцлуулсан бөгөөд бүртгэл хийх үед албан ёсны батлуулаагүй ч Долгортой хамт амьдарч байгаа бол Батын гэрлэлтийн байдлыг “батлуулаагүй гэр бүлтэй” гэж нөхнө.

**А13. Хөдөлмөр эрхэлдэг эсэх.** Энэ асуултыг 6, түүнээс дээш насны бүх хүнээс бүртгэх үеийн өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин, орлоготой ажил эрхэлсэн эсэхээр тодруулж асууна.

Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн буюу “Тийм-1” гэсэн кодыг дарааж шалд дугуйлна. Үүнд:

- Өмнөх 7 хоногийн турш эсвэл аль нэг өдөр цалин, орлоготой ажил эрхэлсэн бүх хүн,
- Ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын эрхлэгч, өмчийн хэлбэр, тухайн үний эрхэлж байгаа ажлын зэрэг дэвийг харгалзахгүй гээр ажил эрхэлж байгаа бүх хүн, мөн зах, гудамж талбайд наймаа, худалдаа хийгч, гутал тослогч, сонин борлуулагч, машин угаагч, сийлбэрчин, түүхий эд цуглуулагч зэрэг албан бусаар ажилладаг хүн,
- Өмнөх 7 хоногт ажиллаж боловч үндсэн байгууллагатайгаа хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй, тодорхой хугацааны дараа ажилдаа эргэн орох дараах хүмүүс. Үүнд:
  - Жирэмсний, хүүхэд төрүүлсний амралт болон 2 хүртэлх настай хүүхдээ асрахаар ажлаас чөлөө авсан,
  - Өвчний болон гэмтсэний улмаас урт, богино хугацааны чөлөө авсан,

- Захиргааны түр чөлөөтэй хүн (цалинтай, цалингүй харгалзахгүй),
- Ээлжийн амралтаа авсан,
- Ажил хаялт зарласан,
- Газар тариалан, алт олборлох, барилга, геологи хайгуул зэрэг улирлын чанартай ажил, үйлдвэрлэл эрхэлдэг учраас өвлийн улиралд түр ажиллахгүй байгаа,
- Аж ахуйн нэгж, байгууллага нь ямар нэг шалтгаанаар (ажилчид нь ажил хаясан, үйлдвэрлэлийн осол гарсан, байгалийн хүнд нөхцөл, цахилгаан түүхий эд, түлш тасарсан гэх мэт) ажлаа зогсоосон, сургалтад хамрагдсан болон бусад шалтгааны улмаар хугацаагаар ажил хийгээгүй хүмүүсийг хамааруулна.

Дээрх асуултад **тийм** буюу “1” гэж хариулсан бол асуултыг үргэлжлүүлэн асууна. Харин **үгүй** буюу “2” гэж хариулсан бол **A15-р** асуулт (орлогын хэлбэр) руу шууд шилжинэ. “**Үгүй**” буюу “2” гэсэн кодыг өжөхийн өмнө хөдөлмөр эрхлээгүй гэж хариулсан хүмүүстэй сайтар ярилцаж, шалтгааныг тодруулах хэрэгтэй.

**A14. Хөдөлмөр эрхлэлтийн байдал.** Энэ асуултыг **A13-р** асуултад “**Тийм**” буюу “1” гэсэн хариулт өгсөн 15, түүнээс дээш насны бүх хүнээс асууж, нөхнө. Тухайн хүний эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагадаа үйцэтгэж байгаа үүрэг, байгуулсан гэрээ хэлцлийн байдлыг үндэслэн аль тохирох хариултын кодыг дугуйлна. Хөдөлмөр эрхлэлтийн байдал (статус) гэдэг нь ажил эрхэлж байгаа хүний ажилладаг байгууллага болон олон хувь хүнтэй байгуулсан гэрээгээр тодорхойлогдох бөгөөд тухайн хүний ажлын байртай холбогдох байр суурь болон байгууллага бусад хүмүүстэй харилцах эрх мэдлийг илэрхийлнэ.

Тухайн хүн хоёр өөр төрлийн ажил эрхэлж, түүний хөдөлмөр эрхлэлтийн статус нь ялгаатай байвал ажлын цагийн ихэнхийг зарцуулдаг ажлыг бичнэ. Хэрэв яг ижил цаг зарцуулж байвал орлогын ихэнхийг олдог ажлыг хөдөлмөр эрхлэлтийн статусыг авч үзнэ.

*Цалин хөлстэй ажиллагч.* Хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах аман болон бичгээр хийсэн гэрээ, хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчид ажилчилчигчид үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг иргэнийг хэлнэ. **Цалин хөлстэй** ажиллагчид доорх хүнийг хамруулна.

*Төр, захиргаа, төсвийн байгууллагын бүх албан хаагчид.* Төр, захиргаа, төсвийн байгууллагад ажилладаг, томилогдсон буюу сонгогдсон, хүнийг ажилд авах болон халах эрх мэдэлтэй, тухайн байгууллагын ажиллагааны талаар шийдвэр гаргах эрхтэй, түүнтэй холбогдсон хариуцлага хүлээдэг хүмүүсийг энэ ангилалд хамаарах бөгөөд (яамдын сайд, засаг дарга гэх мэт) ажил олгогч гэж үзэхгүй. Учир нь эдгээр хүмүүс улсын төсвөөс цалинжиж, төрийн байгууллагад ажиллаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хувийн байгууллагад хүн авч ажиллуулж байгаа биш гэдгийг ойлгох хэрэгтэй.

*Аж ахуйн нэгжид цалин хөлстэй ажиллагчид.* Хувийн компани, хоршоо, нөхөрлөл, хувийн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагч, дагалдан ажиллагч

буюу сурагч (хувийн хувиараа эрхлэх аж ахуй, хоршоо, нөхөрлөлийн эзэн, хоршооны гишүүн энд орохгүй); төрийн өмчит үйлдвэрийн газар, компанид ажиллагч, дагалдан ажиллагч; хувь хүнтэй гэрээгээр ажиллагч нэг ангилалд багтана.

*Төрийн бус байгууллагын ажиллагчид.* Үйлдвэрчний эвлэл, улс төрийн нам, хөдөлгөөн гэх мэт олон нийтийн байгууллага; шашны, буяны болон хүмүүнлэгийн байгууллага; бусад өрийн бус байгууллагад ажиллагч ид хамаарна.

*Бусад хөлсөөр ажиллагчид.* Гэрийн үйлчлэгч; хүүхэд асрагч; мал аж ахуй, газар тариаланд ажиллагч; хүн тээврийн үйлчилгээнд ажиллагчид гэх мэт;

*Ажил олгогч.* Эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр ийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар (6, үүнээс дээш сараар) нэг буюу үүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хэлнэ. Жишээлбэл, хувийн аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, хоршооны эзэн-захирал ажил олгогч болно. Харин эзэн нь биш, сонгогдсон буюу томилогдсон захирал бол ажил олгогч биш, цалин хөлстэй ажиллагч болно. Хэрэв өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх тогтмол хүн авч ажиллуулдаг, тухайлбал, малтай айл өөр өрхөд мөнгөн болон биет хэлбэрээр хөлс өгч малаа маллуулдаг бол **хувиараа хөдөлмөр эрхлэгч** биш харин **ажил олгогч** болно.

*Хувиараа хөдөлмөр эрхлэгч.* Бие даан буюу бусадтай хамт төрийн багаж, тоног төхөөрөмж, бусад материалыг ашиглан эдийн засгийн үйл ажиллагааг хараат бусаар явуулж, урт хугацаагаар (6, үүнээс дээш сараар) ажилтан авч ажиллуулдаггүй (богино хугацаагаар түр авч ажиллуулж болно), бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрийг бие даан гаргадаг иргэнийг хэлнэ. Үүнд хүнийг тогтмол авч ажиллуулдаггүй дараах хүмүүс орно.

- Хувийн аж ахуйн нэгж, байгууллагын эзэн захирал өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг өөр ашиг орлоготой үйл ажиллагаа эрхэлдэг үй) өрхийн тэргүүлэгч;
- Зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй хувиараа ажил эрхэлж байгаа бүх хүмүүсийг хувиараа хөдөлмөр эрхлэгч гэнэ. Жишээлбэл, мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрхийн тэргүүлэгчийг (өөр ашиг орлоготой үйл ажиллагаа эрхэлдэггүй) үйлдвэрлэлдээ тогтмол хүн авч ажиллуулдаггүй тохиолдолд хувиараа хөдөлмөр эрхлэгч гэж үзнэ.

*Нөхөрлөл, хоршооны гишүүн.* Үйлдвэрлэл, үйлчилгээний нөхөрлөл, хоршоонд өөрийн эд хөрөнгө, хөдөлмөрөө сайн дураар нэгтгэж гишүүнээр элссэн, үйлдвэрлэл, борлуулалт зэрэг байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон гишүүдийн дунд ашиг хуваарилах асуудлыг шийдвэрлэхэд бусад гишүүдтэй адил тэгш оролцдог иргэнийг,

*Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч:* Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцож, хувийн хэрэглээгээ хангаж буй тухай өрхийн гишүүн болон тухайн өрхөд хамт амьдрахгүйгээр аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд нь оролцож байгаа иргэнийг хэлнэ.

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг өрхийн тэргүүлэгчээс бусад (өөр цалин орлоготой хөдөлмөр эрхэлдэггүй) гишүүд; тухайн өрхийн гишүүн биш боловч өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд нь оролцож тусалдаг хүмүүс тухайлбал, хамаатан садны айлдаа мал маллахад тусалж, гэрт нь амьдардаг хүмүүс энд орно.

*Бусад.* Тэдний талаар зохих мэдээлэл хангагдсвэл дээр дурдсан ангиллын аль нэгэнд хамруулах боломжтой ажиллагчдыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, дээр заагдсан өдөлмөр эрхлэлтийн байдал (статус)-ын ангиллаар ангилах боломжгүй тохиолдолд энэ бүлэгт хамруулна.

**A15. Орлогын хэлбэр.** Энэ асуултыг 15, түүнээс дээш насны бүх хүнээс асууж харгалзах кодыг өвхөж бичнэ. Хэрэв орлогын 2 эхүсвэртэй бол дийлэнх орлого олдог хэлбэрийг авна.

**A16. Хөдөлмөр эрхэлдэггүй шалтгаан.** Өрхийн гишүүдийн бүртгэлийн 13-р асуултад ажил эрхэлдэггүй буюу "2" гэж хариулсан хүнээс асуух бөгөөд, сайтар ярилцаж, тухайн хүний ажил эрхлэхгүй байгаа хамгийн гол шалтгааныг тодруулан тохирох кодыг дугуйлна.

*Сургуульд сурдаг.* Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн анхан болон дунд шатны сургууль, мэргэжлийн сургалт, үйлвэрлэлийн төв, 6 сараас дээш хугацаагаар мэргэжлийн сургалтад хамрагдагч, өрнхий боловсролын сургуульд суралцаж буй иргэнийг хамруулна.

*Тэтгэвэрт.* Өндөр насны тэтгэвэрт энгийн боловнхөлөлттэй, тусгай нөхцөлөөр гарсан хүмүүсийг үүнд хамруулна.

*Хөдөлмөр эрхлэх чадваргүй* хүн гэж албан ёсны эрх үхий байгууллагын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан нь тогтоогдсон, өдөлмөрийн насны, мөн хөгжлийн бэрхшээлтэй болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө групп тогтоолгосон хүнийг (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) ойлгоно.

Өвчний болон гэмтсэний улмаас бүртгэлийн өмнөх 7 хоногт түр ажиллахгүй байгаа боловч ажилладаг байгууллагатайгаар өдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй, тодорхой хугацааны дараа ажилдаа эргэн орох хүмүүс **хөдөлмөр эрхэлдэг хүн амд** орно.

*Гэрийн ажилтай.* Бага насны хүүхэд, өвчтөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан асардаг, гэр бүлийн хүний ажлын онцлогоос шалтгаалан ажил эрхэлдэггүй, зөвхөн гэрийн ажил хийдэг хүмүүсийг энд хамааруулна.

Хуулийн дагуу жирэмсний болон хүүхэд төрүүлсний амралт, 2 хүртэлх насны хүүхдээ асардаг захиргааны чөлөөтэй байгаа хүмүүс, цалин хөлстэйгээр гэрийн үйлчлэгч хийж байгаа хүмүүс, биет болон мөнгөн орлого олох зорилгоор гэртээ ажил хийдэг хүмүүс **ажил эрхэлдэг хүн амд** орно.

*Тохирох ажил олдохгүй байгаа.* Ажил хийхийг үсч байгаа, ажил хийхэд бэлэн, урьд нь ажил идэвхтэй хайж байгаад тохирох ажилгүй олдог алдарсны улмаас үртгэхээс өмнөх 7 хоногт ажил идэвхтэй хайгаагүй, эсвэл тохирох ажлыг хаанаас хайхаа мэдэхгүй байгаа, тохирох ажил олдохгүй гэж үзэж байгаа хүмүүсийг энд хамааруулна.

*Ажил хайж байгаа.* Хөдөлмөр эрхлэлтийн албанд үртгүүлсэн болон бүртгүүлээгүй иргэнийг хэлнэ. Бүртгэлийн өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүнийг **ажил хайж байгаа** гэж үзнэ.

*Ажиллах сонирхолгүй.* Хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадвартай боловч цалинөлжтэй болон хувиараа хөдөлмөрлөж эдийн засгийн үйл ажиллагаанд ажиллах хүчээ нийлүүлэх сонирхолгүй хүнийг энд хамруулна.

*Бусад.* Дээр дурьдсанаас бусад өөр шалтгаанаар ажил хийхгүй байгаа хүмүүсийг энд хамруулна.

**A17. Цэргийн алба хаасан эсэх.** Арван найм, үүнээс дээш насны эрэгтэйчүүдээс хугацаат цэргийн алба хаасан эсэхийг асууж, тохирох кодыг нөхнө.

#### IV. ӨРХИЙН БҮРТГЭЛ

##### Өрхийн сууцны нөхцөл

Өрхийн сууцны нөхцөл, бүтцийн хангамж тодорхойлох үзүүлэлтэд сууцны төрөл, талбайн хэмжээ, сууцны эзэмшил, халаалтын болон цахилгааны эх үүсвэр, усан хангамж, бохир ус, хатуу хог хаягдал зайлуулалтын талварлэлтийг хамааруулна.

**B1. Сууцны төрөл.** Орон сууцны холбогдох асуултаар өөхдөө доорх тодорхойлолтын дагуу өрхийн сууцны төрлийг тодорхойлон **Гэрт суудаг** бол “11”, **Орон сууцны байшинд суудаг** бол “21”, **Бие даасан тохилог сууц** бол “22”, **Сууцны тусдаа байшин** бол “23”, **Нийтийн байр** бол “24”, **Бусад сууцанд амьдардаг** бол “31” гэсэн кодыг мөр “B1”-ийн эхний мөрөнд бичнэ.

B1-ийн хоёр дахь мөрөнд тухайн өрхийн сууцны төрлөөс хамааран гэрт суудаг бол ханын тоо, байшин болон бусад сууцанд суудаг бол тухайн сууцны талбайн хэмжээг м<sup>2</sup>-аар тооцон харгалзах нүдэнд бичнэ. Жишээг доорх зургаар харуулав.

Тухайн өрх сууцны хоёроос дээш байшин, гэртэй эсвэл байшин, гэр хоёуланг эзэмшдэг тохиолдолд голлон амьдардаг бүрхүүн гишүүдийн олонх нь амьдардаг сууцаар нь асуулгыг нөхнө. Жишээлбэл,

№	СУУЦНЫ НӨХЦӨЛ	201...
B1	СУУЦНЫ ТӨРӨЛ	21
	ХАНЫН ТОО/ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ (М <sup>2</sup> )	37

Өрх, хүн амын амьдарч байгаа сууцыг төрлөөр нь гэр, байшин, бусад сууц гэж 3 ангилна. Үүнд:

1. **Гэр.** Бүх төрлийн монгол гэр болон цаатны урцыг хамааруулна.
2. **Байшин.** Байшин гэж нэг болон олон өрө өтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууриас дээвэр үртэл ханаар хув аагдсан талбай бүхий орон байрыг ойлгоно. Байшинд орон сууцны байшин, бие даасан тохилог сууц (хаус), сууцны тусдаа байшин (гэр хорооллын хашаанд барьсан тоосгон, модон,

чулуун, шавар ханатай сууцны байшин), нийтийн байр болон нийтийн зориулалтын бусад байр орно.

2.1. Орон сууцны байшин. Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалтай, бүртгэл хийх үед бүхлээрээ үн амьдраха ас өөр зорилго ор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусд аа нэг буюу хэд хэдэнөрө ө тасалгаа, бүрэн тоноглол төх өөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь дэд бүтцийн бүх төрлийн суурь хангамжаар тоноглогдсон, дараах үүхцөлийг бүрэн бүрдү үлсэн байна. Үүнд:

- a. Цахилгаан, дулааны шугамүлж ээ болон усан хангамжийн сүлжээтэй
- b. Сууцны дотор бие засах газартай;
- c. Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй;
- d. Зориулалтын гал тогоо болон хоол хийх талбайтай байна.

2.2. Бие даасан тохилог сууц. Бие даасан тохилог сууц (хаус) нь нэрх амьдрах зориулалтай, төвлөрсөн инженерийн шугам сүлжэ эний системд холбогдсон эсвэл инженерийн шугамүлж эний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татдаг) байна. Өрө ө тасалгаа нь өөр айлын сууцны өрө ө, тасалгааны дээр байрлаагүй, орц, туслах өрөө тасалгаа, дэврийн хөндий, зоорийн давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалтай сууцыг үүнд хамааруулна. Сууцны өрөө /унтлагын ба зочны/, гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрө ө, агуулах, ханын үлжэ этэй үн мансардтай болон мансардгүй байж болно.

2.3. Сууцны тусдаа байшин. Ихэвчлэн гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрө өтэй, дэд бүтцийн (гал тог оо, онгоц, шүршүүр, халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.


2.4. Нийтийн байр. Иргэд бө өнөөрөө буюу хэсэг бүлг ээрээ амьдран суудаг, олон өрө өтэй, бүртгэх үед хүн амьдарч байгаа сууцыг нийтийн байранд хамааруулна. Нийтийн байр нь ихэвчлэн нийтийн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байдаг. Нийтийн байр гэдэгт оюутан, сурагчдын дотуур байр, байгууллагын ажиллагчдын байр, зочид буудал, бусад зориулалтын нийтийн байр орно.

3. **Бусад сууц**. Анхнаасаа үн амьдрах зориулалтаар бариагүй эсвэл үн амьдрахад зориулан өөрчлөн засаж тохижуулсан сууц багтана. Энэ нь сургууль, үйлдвэр, албан газар, байгууллагын хэсэг буюу өө тасалгаанд (зориулалтаараа аж ахуйн нэгж, байгууллага байрлахад зориулагдсан) өрх айл, хүн амьдарч байгаа, мөн байнгын бус, түр орогнох, хүн амьдрахад тохиромжгүй байр, талбайг бусад сууц гэж үзнэ. Жишээлбэл, вагончик, амбаар, пин, агуулах, дэлгүүр, мухлаг, байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжэ эний

худаг (траншей), ой мод, уул хад, агуй зэрэг зэрэгтөрх айл, хүн амьдарч байгаа бол бусад сууц гэж үзнэ.

**Сууцны талбайн хэмжээ нь хүн амьдрах талбай** (амралтын, унтлагын, хүүхдийн, ажлын болон хооллох өрөө), **туслах өрөө, тасалгаа** (гал тогооны, угаалгын, бие засах өрөө, хонгил, ханын шүүгээ, агуулах)-ны талбайн нийлбэр байна.

**Хүн амьдрах талбай** (Амралтын **S1**, унтлагын **S2**, хүүхдийн **S3**, ажлын, хооллох өрөөнүүд **SA**), **туслах өрөө, тасалгаа** (Гал тогооны **S4**, ариун цэврийн өрөө **S5**, хонгил **S6**, ханын шүүгээ **S7**, агуулах **S8**)-г доорх зургаас харна уу. Хооллох өрөө нь амралтын буюу зочны өрөөний дэргэд тусдаа өрөө (ихэнх тохиолдолд) байж болно. Эсвэл амралтын буюу зочны өрөөний нэг булан, хэсэгт ханаар тусгаарлагдсан буюу тусгаарлагдагүй байж болно.



Айлын хажуу өрөө хөлслөн суудаг өрхийн хувьд сууж буй өрөөний талбай нь сууцны талбай болно. Хариулагч сууцныхаа талбайг мэдэж тохиолдолд сууц эзэмшигчийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ зэргийг үзэх талаар зөвлөж болно. Хэрэв шинээр баригдсан барилгыг худалдаж авсан бол сууцны хөлс төлж байгаа талбай байна. Хувиараа барьсан сууцны хувьд эздээр нь талбайг хэмжүүлэх зэрэг сууцны талбайгаа үнэн бодитой тодорхойлох боломжтой бусад аргыг хэрэглэхийг зөвлөж хэрэгтэй.

**В2. Эзэмшлийн хэлбэр.** Сууцны эзэмшил нь өмчлөлөөс ялгаатай бөгөөд тухайн өрх өөрийн өмчийн сууцандаа амьдардаг эсвэл бусдын өмчийн сууцыг түрээсэлдэг, түрээсийн төлбөр төлөхгүй болон бусад хэлбэрээр эзэмшиж, ашиглаж байгааг харуулна. Тухайн өрх, хувь хүн амьдарч байгаа орон сууцны эзэмшлийг **Өөрийн эзэмшлийн** буюу “1”, **Бусдын сууцанд түрээстэй суудаг** буюу “2”, **Бусдын сууцанд түрээсгүй суудаг** буюу “3” гэсэн кодын аль тохирохыг нөхнө.

**Өөрийн эзэмшлийн.** Сууцаа хувьчилж авсан болон худалдаж авсан өөр өө барьсан хувийн өмчийн сууцыг өөрийн эзэмшлийн сууцанд хамааруулна.

**Бусдын сууцанд түрээстэй суудаг .** Төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагын эсвэл бусдын хувийн өмчийн сууцыг түрээслэн амьдарч байгаа өрх, хүн амын сууцыг түрээсийн сууц гэж ойлгоно. Сууц ашиглалттай холбоотой төлж буй зардлыг түрээс гэж үзэхгүй.

**Бусдын сууцанд түрээсгүй суудаг .** Төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагын эсвэл бусдын хувийн өмчийн сууцанд түрээсийн төлбөр төлөхгүйгээр амьдарч байгаа өрх, хүн амын сууцыг бусдын сууцанд түрээсгүй суудаг гэж үзнэ.

**В3. Цахилгааны эх үүсвэр .** Цахилгааны эхүүсвэрийг усан болон дулааны цахилгаан станц; дизель станц; сэргээгдэх эрчим үчний төхөөрөмж буюу нар, салхины эрчим үчний төхөөрөмж, бага оврын цахилгаан үүсгүүр болон огт цахилгааны эх үүсвэргүй гэж ангилна.

Тухайн өрх, хүн ам хэд хэдэн цахилгааны эх үүсвэртэй байж болно. Энэ тохиолдолд сууцны цахилгааны үндс эн эхүүсвэрийн талаар асууж, **Төвлөрсөн систем** буюу “1”, **Дизель станц** буюу “2”, **Сэргээгдэх эрчим үчний төхөөрөмж** буюу “3”, **Бага оврын цахилгаан үүсгүүр** буюу “4” гэж өгөгдсөн хариултаас аль тохирохыг нь сонгож харгалзах кодыг дугуйлна. Хэрвээ цахилгаан огт хэрэглэдэггүй бол **Цахилгааны эх үүсвэргүй** буюу “5” гэсэн кодыг дугуйлна.

- **Төвлөрсөн систем.** Улсын цахилгаан болон усан станцаас цахилгаанаа авдаг сууцыг төвлөрсөн системтэй гэж үзнэ. Цахилгаан станцад холбогдсон цахилгааны сүлжээг (дэд станц) төвлөрсөн систем гэж ойлгоно.
- **Дизель станц.** Энд тусгайлан барьсан дизель станцад холбогдсон цахилгааны сүлжээг ойлгох бөгөөд орон нутгийн хувьд бие даасан дизель станцтай холбогдсон цахилгааны сүлжээтэй орон сууцыг хамааруулна.
- **Сэргээгдэх эрчим үчний төхөөрөмж .** Нар, салхины эрчим үчийг хуримтлуулан цахилгаан эрчим болгодог төхөөрөмжийг үүнд хамааруулна.
- **Бага оврын цахилгаан үүсгүүр .** Тухайн нэг өрх болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах зорилгоор шатах болон бусад материалаар ажилладаг бага оврын мотор, цахилгаан үүсгүүрийг үүнд хамааруулна.

**В4. Халаалтын эх үүсвэр.** Сууцыг дулаан байлгах зориулалттай халаалтын системийн төрөл энд хамаарах бөгөөд байрыг бүхэлд нь халаах зориулалттай дулааны төвлөрсөн систем, нам даралтын зуух, пийшин, ердийн зуух болон бусад төрлийн халаагч байж болно. Сууцны дулааны буюу халаалтын үндсэн эх үүсвэрийн талаар асууж, **Төвлөрсөн систем** буюу “1”, **Нам даралтын зуух** буюу “2”, **Цахилгаан халаагуур** буюу “3”, **Ердийн галлагаа** буюу “4” гэсэн хариултаас тохирохыг сонгож, харгалзах кодыг дугуйлна.

- **Төвлөрсөн систем.** Улсын болон тухайн орон нутгийн хувьд дулааны цахилгаан станц, уурын зуухтай холбогдсон дулааны сүлжээтэй сууцыг төвлөрсөн халаалттай гэж үзнэ.
- **Нам даралтын зуух.** Нэг болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах үүднээс нэгдсэн халаалтын үүсвэрт ашиглаж буй бага оврын зуухыг үүнд оруулна.

- **Цахилгаан халаагуур.** Тухайн өрхийн хэрэгцээг хангах үүднээс цахилгаан эрчимчээр ажилладаг халаах төхөөрөмжийг үүнд хамааруулна.
- **Ердийн галлагаа.** Энгийнээр галлаж, халаадаг зуух, пийшинтэй бол ердийн галлагаатай гэнэ.
- Жишээлбэл, Оргилынх дулааны цахилгаан станцтай холбогдсон төвлөрсөн системээс дулаанаа авдаг буюу паараар (уураар) байшингаа халаадаг бол дулааны эхүүсвэр нь **Төвлөрсөн систем** буюу “1” байна. Оргилын эгч Мөнхгэрэлийнх шалнаасаа халдаг цахилгаан халаагууртай бол **Цахилгаан халаагуур** буюу “3”, Харин Оргилын аавынх байшингаа ханан пийшингээр, **өдөө амьдардаг Батын гэр бүлийнхэн** зуух галлаж гэрээ дулаацуулдаг бол **Ердийн галлагаа** буюу “4” гэсэн кодыг тус тус дугуйлна.

**В5. Усан хангамж.** Орон сууц нь ус дамжуулах төвлөрсөн болон бие даасан усан хангамжийн системтэй, эсвэл худаг, булаг, шанд, гол, мөрөн, нуураас усаа авдаг зөөврийн усан хангамжтай талаар асууж нөхнө.

**Төвлөрсөн усан хангамж** гэж улсын болон тухайн орон нутгийн дулаан, усан хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас орон сууцны байшин, бие даасан тохилог сууц, нийтийн байр болон нийтийн зориулалтын бусад байранд төвлөрсөн байдлаар ус түгээж байгаа системийг оруулна. Төвлөрсөн усан хангамж нь төрийн мэдэлд байдаг бөгөөд төвлөрсөн сүлжээг ихэвчлэн төрийн байгууллага ажиллуулдаг боловч зарим тохиолдолд хоршоо болон хувийн аж ахуйн нэгж хариуцан ажиллуулдаг.

#### **Төвлөрсөн бус усан хангамж.**

- **Бие даасан систем** гэж тухайн сууцны хэрэгцээг хангах зорилгоор суурилуулсан бага хэмжээний, улсын болон орон нутгийн дулаан, усан хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас хамааруулж бие даасан байдлаар ус түгээж байгаа системийг ойлгоно. Тухайлбал, бие даасан тохилог сууц болон сууцны тусдаа байшинд ихэвчлэн тохиолддог ус халаах бойлуур, зөвхөн өрхийн хэрэгцээг хангахад зориулагдсан бага оврын ус түгээх систем гэх мэтийг ойлгоно.
- **Зөөврийн** усан хангамжид өрхийн хувьд **ус өдөг** хэрэгслийн төрөл, хэлбэрээс үл хамааран, ус авч байгаа хэлбэр болох усны машинаар зөөвөрлөдөг ус, ус түгээх байр (тухайлбал, усны машинаар зөөж хийдэг худаг гэх мэт), үний худаг (зураг төслийн дагуу малтаж баригдсан мотор буюу бусад өхөөрөмжөөр усаа шууд авдаг худаг), уурх айн худаг (иргэд өөрсдөө малтсан энгийн худаг), усны том саваар хураасан ус, усан сан, суваг, усжуулалтын хоолой, булаг, шанд, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн ус, борооны болон тогтоол усыг хамааруулна.

**Төвлөрсөн усан хангамжтай**, халуун, үйтэн устай тохиолдолд “11”, **төвлөрсөн усан хангамжтай**, хүйтэн устай тохиолдолд “21”, төвлөрсөн бус усан хангамжтай буюу, **бие даасан системтэй**, хүйтэн устай тохиолдолд бол “22” гэсэн кодыг дугуйлна. Харин ямар нэгэн **усээх** системд холбогдоогүй **зөөврийн** тохиолдолд “13” гэсэн кодыг нөхнө.

**В6. Бохир ус зайлуулалт.** Ахуйн хэрэглээнээс гарсан бохироо зайлуулж байгаа арга, хэлбэрийг ойлгоно. Хэрэглээнээс гарсан бохир усыг хэрхэн зайлуулж байгааг дараах байдлаар тодорхойлно.

**Төвлөрсөн системд** улсын болон тухайн орон нутгийн бохир ус зайлуулалт хариуцсан аж ахуйн нэгж, байгууллага орон сууцны байшин, бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин, нийтийн байр болон нийтийн зориулалтын бусад байрны төвлөрсөн байдлаар бохир ус зайлуулдаг системийг оруулна.

**Бие даасан системд** тухайн орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор суурилуулсан, орон нутгийн усан хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас хамааралгүйгээр бохир ус зайлуулах бага хэмжээний системийг оруулна. Тухайлбал, хувийн болон амины орон сууцны ~~өвхөн~~ өрхийн хэрэгцээг хангахад зориулсан бохир ус зайлуулах, бага оврын систем (бохир, ялгадас саармагжуулах танк) орно.

**Цооногт.** Муу усны зориулалтын цооног болон жорлонгийн нүхэнд бохир усаа асгаж зайлуулахыг ойлгоно.

**Задгай.** Бохир ус зайлуулах тусгайлан зориулсан цооноггүй, задгай газарт бохир усаа асгадаг болон өөх, булах гэх мэт гар аргаар бохирыг зайлуулдаг тохиолдлууд орно.

Бохир усыг *төвлөрсөн болон бие даасан системээр, цооногт эсвэл задгай асгадаг* аль нь болохыг тодруулж, кодыг дугуйлна.

**В7. Хатуу хог, хаягдал зайлуулалт.** Хог хаягдлыг **үйлчилгээний байгууллагаар, зөвшөөрөгдсөн цэгт, тогтсон газар байхгүй** гэсэн төрлийн аль тохирохоор нөхнө. Малын ялгадас, үс ноосыг хог хаягдалд оруулахгүй.

**Үйлчилгээний байгууллагаар.** Улсын болон тухайн орон нутгийн албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллага эсвэл *бусадтай (хог ачигчтай) гэрээ хийж*, хог хаягдлыг *тогтмол эсвэл тогтмол бус хугацаагаар* ачиж зайлуулдаг тохиолдлыг хамааруулна. Жишээлбэл, хот, суурин газрын гол төлөв угсармал орон сууцны орц бүрт байдаг хог зайлуулах зориулалтын хоолой эсвэл сууцны гадна байрладаг хогийн цэгээр зайлуулдаг тохиолдлыг ойлгоно.

**Зөвшөөрөгдсөн цэгт.** Албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллагын зааварчилгаагаар эсвэл албан зохицуулалтгүйгээр оршин суугчид хогоо нийтийн хогийн газар болон тодорхой төвлөрсөн цэгт зайлуулдаг тохиолдлыг хамааруулна.

**Тогтсон газар байхгүй** гэж тухайн өрх айл хог зайлуулах тодорхой газаргүй, хогоо ил задгай хаядаг, булдаг, шатаадаг тохиолдлыг ойлгоно.

### **Өрхийн аж ахуй**

Өрхийн аж ахуйн үзүүлэлтэд мал, тэжээвэр амьтан, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, тээврийн хэрэгсэл, компьютер, интернэт зэргийг хамааруулсан.

**С1. Мал, тэжээвэр амьтантай эсэх.** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргаанд үүсвэр болдог өрхийг

“малчин өрх”, юн малыг ахуй амьдралдаа туслах чанарыг үүрэгтэй өсгөн үржүүлдэг малтай бүх өрхийг “мал бүхий өрх” гэж үзэж бүртгэнэ.

Тэжээвэр амьтдыг (гахай, шувуу у (тахиа, галуу), цаа буа, илэгий, з туулай зэрэгүр ашиг өгдөг амьтад) ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг, эсвэл тэжээвэр амьтдын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрхийг н хувьд нөхөгдөнө. Тухайн өрхийн мал, тэжээвэр амьтантай эсэхийг дээр дурдсан зааврын дагуу тодорхойлж, **Тийм** буюу “1”, **Үгүй** буюу “2” гэсэн кодын аль тохирохыг дугуйлна.

**С2. Газар тариалан эрхэлдэг эсэх.** Газар тариаланг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй эрхэлдэг, эсвэл газар тариалангийн бүтээгдэхүүн тэдний амьжиргааны үндсэн эх үүсвэр нь болж байгаа өрхийг бүртгэлд хамруулна. Хүлэмжийн талбайг тариалсан талбайд оруулна. Тариалан эрхэлдэг өрхөд орон сууцны тагт болон гэрийн нөхцөлд сонгино, сармис, улаан лооль, өргөст хэмх зэрэг хүнсний ногоог бага хэмжээгээр тарьж, хэрэглэдэг өрхүүд хамрагдахгүй.

Аж ахуйн нэгж, байгууллагын болон бусдын эзэмшилд байгаа газарт тариалалт хийж, өвхөн ажлын хөлсийг /цалин эсвэл биет хэлбэрээр/ авч, хураасан ургацыг талбай эзэмшигчид өгдөг бол уг өрх бүртгэлд хамрагдахгүй. Харин газар тариалан эрхэлж байгаа өрх нь өөрийн газаргүй боловч бусдын газрыг түрээслэн тариалж, ашиг шимийг нь өөрөө хүртдэг бол тухайн өрхийг газар тариалан эрхэлдэг өрх гэж үзэн бүртгэлд хамруулна.

Тариалангийн талбайн хэмжээг метр квадрат( $m^2$ )-аар тодорхойлж, харгалзах нүдэнд тоог бичнэ.

**Үүнд: 1 сот=100 метр квадрат,  
1 га =10000 метр квадрат.**

**С3. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг эсэх.** Өөрийн өмчийн болон эзэмшлийн газарт үйлдвэр үйлчилгээ эрхлэх, үрээслүү лэх зэргээр ахуй амьдралдаа туслах чанарыг үүрэгтэй и, эсвэл амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрхийг бүртгэлд хамруулна. Тухайн өрх **үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг** бол “1”, хөрөнгөө **түрээслүүлдэг** бол “2”, аль аль нь байхгүй бол “3” гэсэн кодыг дугуйлна.

**Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг.** Эзэмшлийн хэлбэр харгалзахгүйгээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж орлого олдог өрхийг хамруулна.

**Хөрөнгө түрээслүүлдэг.** Өөрийн эзэмшлийн газар, байр, талбайг түрээслүүлэн орлого олдог өрхийг хамруулна.

**С4. Тээврийн хэрэгсэлтэй эсэх.** Наад захын хэрэгцээндээ, эсвэл хэрэгцээтэй үедээ ашиглаж байгаа өрхийн өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг хамруулна. Хэрэв тухайн суудлын автомашинтай бол “a”, ачааны автомашинтай бол “b”, том оврын болон микро автобустай бол “c”, мотоциклтэй бол “d”, тусгай зориулалтын автомашинтай бол “e”, ямар нэгэн тээврийн хэрэгсэлгүй бол “f” гэсэн кодыг бичнэ. Энэхүү асуултад олон хариулт сонгох бололцоотой.

**Суудлын автомашин.** Өөрийн хийц ба зориулалтын хувь хүн ба тэдгээрийн ачаа, тээшийг тээвэрлэх зориулалттай, жолоочийн суудлыг оролцуулан 9-өөс олонгүй суудалтай авто машин байна.

**Ачааны автомашин.** Хийц, тоноглолын хувьд голөлөв ачаа тээвэрлэх зориулалттай байна.

**Автобус.** Хийц, тоноглолын хувьд зорчигч ба ачаа тээвэрлэх зориулалттай, жолоочийг оролцуулан 9-өөс олон суудалтай байна.

**Мотоцикл.** Шаахайтай буюу шаахайгүй, өөрийн жин нь 400 кг-аас хэтрэхгүй хоёр ба гурван дугуйтай тээврийн хэрэгсэлийг хамруулна.

**Тусгай зориулалтын автомашин.** Хийц, тоноглолын хувьд дараах зориулалтаар ашиглах автомашин орно:үнд: холимог автотээврийн хэрэгсэл, суудлын автомашин, галүймэр унтраах, түргэн тусламж, хог тээвэрлэх, түр сууцны зориулалтаар ашиглагдах гэх мэт автомашин орно.

**С5. Компьютертэй эсэх.** Хүний өдөр тутмын хэрэглээнд зориулагдсан персонал болон зөөврийн компьютер /notebook/, Ipad-ын аль нэг нь өрхөд байгаа тохиолдолд **Тийм** буюу “1”, байхгүй тохиолдолд **Үгүй** буюу “2” гэсэн кодыг дугуйлна.

**С6. Интернэттэй эсэх.** Телефон утас болон түрээсийн шугам, өндөр хурдны хэрэглэгчийн тоон шугам (ДиСЛ, ЭйДиСЛ), байнгын гарцтай, өндөр хурдны кабель модем, шилэн кабелиар интернэтэд холбогдснийг интернэттэй өрхөд хамруулна. Телефон утас (Диал-Ап) гэдэг нь телефон шугам ба модемоор дамжин интернэтэд холбогдох боломж юм.

## **v. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТЭМДЭГЛЭЛ**

Өрх байнга оршин суугаа газраасаа шилжин явах тохиолдолд хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэрт баг, хорооноос зохих тэмдэглэгээг хийлгэн авч явах бөгөөд шилжин очиж буй баг, хороондоо өгч, мөн тэмдэглэгээг хийлгэж бүртгүүлэн үлдээх ёстой. Тэмдэглэгээг шилжихөдөлгөөний бүртгэлийн маягт болох ИУБ 2 2-р маягтыг үндэслэн, баг, хорооны Засаг дарга эсвэл холбогдох ажилтнууд хийж, баталгаажуулсан байна.